



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2010 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Зөвлөлгөөн зохион байгуулах тухай

Монгол Улсын "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль"-ийн 17 дугаар зүйл, тус газрын "Дүрэм"-ийн 3.1, 4.9 заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага MNS 6043:2009 шинэчлэгдсэн стандартыг аж ахуй нэгж байгууллагуудад сурталчилан таниулах, хэрэгжүүлэх, цаашид хамтран ажиллах талаар санал бодлоо солилцох зорилготойгоор 2010 оны 12 дугаар сарын 22,23-ны өдрүүдэд зохион байгуулагдах аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус, аж ахуй нэгж байгууллагуудын удирдлагууд оролцох Удирдах ажилтны зөвлөлгөөний удирдамжийг хавсралтаар баталсугай.

Хоёр.Зөвлөлгөөнд зарцуулагдах нийт 3.234.000 /гурван сая хоёр зуун гучин дөрвөн мянга/ төгрөгийг төлбөр хураамж, бусад зардлаас тооцож гаргахыг ахлах ня-бо /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ш.СҮХБААТАР



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2010 оны 12 сарын 20-ны өдрийн
24 тоот тушаалын хавсралт

**УЛААНБААТАР ХОТЫН НУТАГ ДЭВСГЭРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЯВУУЛЖ БУЙ ЖУУЛЧНЫ БААЗУУДЫН УДИРДАХ АЖИЛТНЫ
ЗӨВЛӨЛГӨӨНИЙ УДИРДАМЖ**

2010.12.20

Нэг. Зорилго

Жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага MNS 6043:2009 шинэчлэгдсэн стандартыг 2009 шинээр батлагдсантай холбогдуулан аж ахуй нэгж байгууллагуудад сурталчилан таниулан, хэрэгжүүлж ажиллах, цаашид шинээр батлах болон өөрчлөлт оруулах стандартын талаар харилцан ярилцах, санал бодлоо солилцоход тус зөвлөлгөөний зорилго оршино.

Хоёр. Зөвлөлгөөний агуулга

Зөвлөлгөөний үеэр Нийслэлийн төр захиргааны байгууллагын зүгээс аялал жуулчлалын болон зочилох үйлчилгээний салбарыг хөгжүүлэх бодлого, ойрын болон урт хугацааны төлөвлөлтүүдийн талаар байгууллага аж ахуйн нэгжүүдэд танилцуулна. Мөн шинээр батлагдан гарсан “Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага MNS 6043:2009” стандартын агуулга болон хэрэглээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө. Цаашид хийх ажлын талаар санал бодлоо солилцох.

Гурав. Зөвлөлгөөнийг зохион байгуулах хугацаа

Зөвлөлгөөнийг 2010 оны 12 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд Голд жим ХХК-ний хурлын зааланд явуулах болно.

Дөрөв. Зөвлөлгөөний зохион байгуулалт

-Зөвлөлгөөний ерөнхий зохион байгуулагчаар Нийслэлийн Аялал жуулчлалын газар.

48

-Энэхүү зөвлөлгөөнд Нийслэлийн төвийн дүүргүүдийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг хамруулна.

- 22,23-ны өдрүүдэд 09.00-15.00 цагийн хооронд семинар зөвлөлгөөнийг зохион байгуулсаны дараа 23-ны өдрийн 16.30-18.30 хооронд тэрэлж дэх жуулчны баазуудаар явж үзүүлэх сургалтыг зохионо.

Тав. Хамтран зохион байгуулагч

Зөвлөлгөөнийг дүүргүүдийн үйлдвэрлэл үйлчилгээний болон мэргэжлийн хяналтын хэлтсүүд, Монголын Аялал жуулчлалын холбоо зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулагчаар оролцоно.

Зургаа. Зөвлөлгөөн зохион байгуулахад шаардагдах зардал

Зөвлөлгөөн зохион байгуулах хурлын танхим болон техник хэрэгсэл, бичиг хэрэг, үдийн хоол, жуулчны баазыг түшиглэсэн үзүүлэх сургалт руу явах унааны зардал зэрэгт шаардагдах нийт 3,234,000 /Гурван сая хоёр зуун гучин дөрвөн мянга /төгрөгийн зардал.

ХЯНАСАН:

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Г.БАЯСГАЛАН

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

С.ЭНХ-АМАР
Б.СОРОНЗОНБОЛД